



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/148

Улаанбаатар хот

Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг үнэлэх журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, Нийслэлийн Статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг үнэлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, үнэлгээний аргачлалыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Аймаг, Нийслэлийн Статистикийн хэлтэс, газрын үйл ажиллагааг шинэчлэн батлагдсан журмын дагуу жил бүр үнэлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Тамгын газар /Ч.Цэвэгдорж/-т үүрэг болгосугай.

3. Дүүргийн Статистикийн хэлтсүүдийн жилийн ажлын үр дүнг үнэлэх журмыг энэ журамтай нийцүүлэн боловсруулж ажиллахыг Нийслэлийн статистикийн газар /Ц.Заяхүү/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны А/163 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг үнэлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



А.АРИУНЗАЯА

000400

Тушаал doc.2018

Үндэсний статистикийн хорооны даргын
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
А/148 тушаалын нэгдүгээр хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС ГАЗРЫН,
ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын “Статистикийн тухай” хууль, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилгоор Үндэсний статистикийн хороо /цаашид ҮСХ гэх/-ноос байнгын хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахад журмын зорилго оршино.

1.2 Энэ журмаар Монгол Улсын “Статистикийн тухай” хууль болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн нийслэл, аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, жилийн ажлын үр дүнг холбогдох шалгуур үзүүлэлтүүдийн дагуу цогцоор үнэлнэ.

1.3 Аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг үнэлэх ажлын хэсгийн даргаар ҮСХ-ны дэд дарга, нарийн бичгийн даргаар Хяналт үнэлгээний чиг үүрэг бүхий нэгжийн дарга, гишүүдэд Хяналт үнэлгээний чиг үүрэг бүхий нэгжийн болон шалгуур үзүүлэлт бүрд үнэлгээ өгөх ҮСХ-ны холбогдох газар, нэгжийн албан хаагчид тус тус ажиллана.

1.4 Ажлын хэсгийн гишүүн нь үнэлгээг гаргахад ашигласан баримт, тооцоог нягтлан шалгаж, холбогдох тайлбарын хамт тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны дотор Ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

1.5 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь үнэлгээг нэгтгэн нийт гишүүдэд танилцуулж, зөвшөөрсөн үнэлгээг нийслэл, аймгийн Статистикийн газар, хэлтсийн дарга нарт урьдчилан танилцуулж, зөвшилцсөн байна.

1.6 Ажлын хэсгийн дарга нь аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үнэлгээг ҮСХ-ны Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Хоёр. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

2.1 Шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1 ҮСХ-ны зорилго, зорилтод нийцсэн байх;

2.1.2 Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэст жигд хэрэгжүүлэх боломжтой байх;

2.1.3 Энгийн, тодорхой, хэмжих боломжтой байх;

2.1.4 Шалгуур үзүүлэлтүүд нь өөр хоорондоо зөрчилгүй, логик уялдаатай байх;

- 2.2 Шалгуур үзүүлэлтүүдийг тооцоход баримтлах зарчмууд:
- 2.2.1 Шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх;
- 2.2.2 Ажлын үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;
- 2.2.3 Үнэлгээ нь тоо баримт, нотолгоонд үндэслэсэн байх;
- 2.2.4 Анхдагч мэдээллийн үнэн, бодит байдлыг хангасан байх;
- 2.3 Ажлын үр дүнг дараах 5 бүлгийн 15 шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд дараах газар, нэгжүүд хариуцан үнэлгээг гаргана. Үүнд: Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлт, хариуцах газар, нэгж

Шалгуур үзүүлэлт		Үнэлэх газар, нэгж	Авбал зохих оноо
Бүлэг 1. Албан ёсны статистикийн мэдээлэл			300
Ш1	Мэдээний хамралт	ЭЗСГ, ХАНСГ	100
Ш2	Мэдээний ирц	МТГ	70
Ш3	Мэдээний бодит байдал, чанар	ЭЗСГ	70
Ш4	Хүн ам, өрхийн мэдээллийн сан	ХАНСГ	30
Ш5	Бизнес регистрийн мэдээллийн сан	ЭЗСГ	30
Бүлэг 2. Тооллого, судалгаа			300
Ш6	Мал, тэжээвэр амьтдын тооллого	ЭЗСГ	75
Ш7	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	ХАНСГ	75
Ш8	Ажиллах хүчний судалгаа	ХАНСГ	75
Ш9	Эдийн засгийн түүвэр судалгаа	ЭЗСГ	75
Бүлэг 3. Статистикийн мэдээлэл тархаалт, сурталчилгаа			100
Ш10	Мэдээлэл тархаалт, вэб баяжилт, сурталчилгаа	ТГ-ОНХХ	100
Бүлэг 4. Төрийн захиргаа, сургалтын үйл ажиллагаа			150
Ш11	Дотоод үйл ажиллагаа	ТГ-ЗХНХ	80
Ш12	Статистикийн сургалтын үйл ажиллагаа	ТГ-ЗХНХ	30
Ш13	Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа	ТГ-ЗХНХ	40
Бүлэг 5. Санхүүгийн үйл ажиллагаа			150
Ш14	Шилэн данс	ТГ-ХШМХ	25
Ш15	Санхүүгийн тайлан	ТГ-СХ	150
Бүлгүүдийн нэгдсэн дүн			1000

2.5 Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлыг дараах томьёоны дагуу 2 оронгийн нарийвчлалаар тооцож, үнэлгээг өгнө. Үүнд:

$$\text{Үнэлгээ} = \frac{\text{Нийт авсан оноо}}{\text{Авбал зохих оноо}} \times 100\%$$

90-100 оноо авсан бол “А” буюу “Маш сайн”
80-89 оноо авсан бол “В” буюу “Сайн”
70-79 оноо авсан бол “С” буюу “Хангалттай”
60-69 оноо авсан бол “D” буюу “Дутагдалтай”
0-59 оноо авсан бол “F” буюу “Хангалтгүй”

Гурав. Шагнал урамшуулал

3.1 Жилийн ажлын үр дүнгээр тэргүүлж, I-III байранд орсон аймаг нийслэлийн статистикийн хэлтэс, газрыг урамшуулах асуудлыг ҮСХ-ны Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

3.2 Нийслэлийн Статистикийн газар нь дүүргийн Статистикийн хэлтсийн жилийн ажлын үр дүнг үнэлэх журмыг энэхүү журамд нийцүүлэн боловсруулан баталж, мөрдөх бөгөөд үнэлгээний дүнг ҮСХ-ны Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, урамшууллыг шийдвэрлүүлнэ.

3.3 Жилийн ажлын үнэлгээгээр “дутагдалтай” болон “хангалтгүй” үнэлэгдсэн аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газрын даргад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

---oOo---

Үндэсний статистикийн хорооны даргын
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
...А/148... тушаалын хоёрдугаар хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС, ГАЗРЫН
ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

Мэдээний хамралт (Ш1): Тайлант хугацаанд мэдээнд хамрагдсан нэгжийн тоог хамрагдвал зохих нийт нэгжийн тоонд харьцуулж оноогоор илэрхийлнэ.

$$Ш1 = \frac{\text{Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо}}{\text{Хамрагдвал зохих статистик нэгжийн тоо}} \times 100$$

Хамрагдвал зохих статистик нэгжийн тоо: Бизнес регистрийн санд бүртгэгдсэн нийт аж ахуйн нэгжийн тооноос тухайн жилд албан ёсны статистикийн сар, улирал, жилийн мэдээнд хамрагдвал зохих статистик нэгжийн жагсаалтаар тодорхойлно.

Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо: Дээрх жагсаалтад үндэслэн мэдээнд хамруулсан статистик нэгжийн тоогоор тооцно. Хэрэв салбарын мэдээ, тайланд шинээр статистик нэгж нэмж хамруулсан бол тэдгээрийг хамрагдвал зохих болон хамруулсан нэгжийн тоонд оруулж тооцно. Шинээр мэдээнд хамруулсан ААНБ-ын мэдээллийг Сангийн яам, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэлтэй тулгаж шалгана.

Мэдээний ирц (Ш2):

$$\text{Шалгуур үзүүлэлт 2} = \frac{\text{Хоцруулаагүй графикт мэдээний тоо (ХГМТ)}}{\text{Нийт графикт мэдээний тоо}} \times 70$$

Нийт графикт мэдээний тооноос шалгуур үзүүлэлт Ш6, Ш7, Ш8, Ш9-ийн мэдээний дамжуулалтын тоог хасаж тооцно.

$\text{ХГМТ} = \text{нийт графикт мэдээний тоо} - \text{хоцроосон графикт мэдээний тоо}$

Графикт хугацаа нь ҮСХ-ны даргын тушаалаар баталсан албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн маягтад заагдсан тэдгээрийг цуглуулах, нэгтгэх, дамжуулах хугацаа байна.

Графикт хугацаанд ирүүлсэн хэдий ч дараах зөрчил, дутагдал илэрвэл хугацаа хоцроосон гэж үзээд оноог хасаж тооцно. Үүнд:

- ҮСХ-ноос боловсруулсан программаар мэдээ тайлангийн үзүүлэлтийг шивээгүй;
- Хоосон файл ирүүлэх;

- Файлын нэр, агуулга, шифр зөрүүтэй (өмнөх сарын мэдээ зэрэг) файл ирүүлэх;
- Буруу хаяг (хувийн)-аар ирүүлэх;
- Тайлант хугацаа зөрүүтэй.

Хугацаа хоцруулаагүй ирүүлсэн ч алдаатай буюу Ш3-т алдсан оноог Ш2-оос давхар хасна.

Мэдээний бодит байдал, чанар (Ш3): Мэдээний бодит байдал, чанарыг эдийн засгийн болон өрх, хүн ам, нийгмийн статистикийн мэдээ, үнийн мэдээ тайланд илэрсэн алдаагаар төлөөлүүлэн хэмжинэ.

Шалгуур үзүүлэлт 3 = Ш3.1 (30.0 оноо) + Ш3.2(10.0 оноо) + Ш3.3(30.0 оноо)

Ш3.1. Эдийн засгийн статистикийн мэдээ: Алдаатай үзүүлэлтийг баталгаажуулах үүднээс дараах 2 байдлаар бүртгэнэ. Үүнд:

- Салбар хариуцсан ажилтнууд ААНБ-ын мэдээнд гарсан үзүүлэлтийн алдааг үзүүлэлтийг дутуу нөхөх, үзүүлэлтийг тайлбаргүйгээр хэт зөрүүтэй ирүүлэх (өссөн буурсан), үзүүлэлтийг орон, цэг, таслалын алдаатай шивэх, маягтад заасан хэмжих нэгжээр тооцож ирүүлээгүй, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүтээгдэхүүн үйлчилгээ, ажил мэргэжлийн болон бусад ангиллын кодыг буруу нөхөх, балансын болон логик (үзүүлэлт хоорондын уялдаа)-ийн алдаа, мэдээ, тайланг нэгтгэснээс хойш болон нийтэд зарласан мэдээлэлд залруулга хийх гэсэн алдааны төрлөөр ангилан бүртгэж, баримтжуулсан байна.
- ААНБ-ын мэдээний алдаатай үзүүлэлтийг програмд бичигдсэн “log” файлыг ашиглан бүртгэнэ. ААНБ-аар ирүүлсэн мэдээний эхний болон сүүлийн “log” файлыг үзүүлэлт бүрээр тулгаж, өөрчлөлт оруулсан бичилтээр “Алдаатай үзүүлэлтийн тоо”-г тодорхойлно.

“log” файлаар бүртгэгдэн гарсан алдаатай үзүүлэлтийн тоог салбар хариуцсан ажилтнууд сайтар нягталж, өөрсдийн алдааны төрлөөр бүртгэн баримтжуулсан алдаатай үзүүлэлтийн тоотой тулгана.

Салбар хариуцсан ажилтнуудын алдааны төрлөөр ангилж алдаатай үзүүлэлтийн тоо нь “log” файлаар бүртгэгдэн гарсан алдаатай үзүүлэлтийн тоотой тэнцүү буюу ойролцоо байна.

Тухайн салбарын мэдээний онцлог байдлаас шалтгаалан гарсан зарим алдааг алдаанд тооцох эсэхийг салбар хариуцсан ажилтан шийднэ. Тухайлбал, мэдээний үзүүлэлтийн сар, улирлын гүйцэтгэл алдаатай байснаас жилийн дүнд буюу өссөн дүнгийн гүйцэтгэлд алдаа гарсныг алдаанд тооцохгүй байж болно. Өөрөөр хэлбэл, нэг нь нөгөөгөөс шалтгаалсан алдааг алдаанд тооцохгүй. Жишээлбэл, Аж үйлдвэрийн сарын мэдээнд сар, улирлын гүйцэтгэлийг алдаатай оруулснаас жилийн гүйцэтгэл программаар бодогдож, алдаатай бүртгэгдэн засагдсан бол алдаанд тооцохгүй.

Дээрх 2 бүртгэл дээр үндэслэн баталгаажуулсан алдаатай үзүүлэлтийн тоог алдааны хувийг тооцоход ашиглана.

$$\text{ШЗ.1} = \left(1 - \frac{\text{Алдаатай үзүүлэлтийн тоо}_i}{\text{Нөхөж ирүүлсэн нийт үзүүлэлтийн тоо}_i}\right) \times 30$$

i – тухайн салбар

ШЗ.2. Хүн ам, нийгмийн статистикийн мэдээ: Дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

$$\text{ШЗ} = \text{ШЗ.2.1 (5.0 оноо)} + \text{ШЗ.2.2 (5.0 оноо)}$$

ШЗ.2.1. Аймаг/нийслэл, сум/дүүргийн мэдээ (НҮ-1, НЗҮ-1, ХА-1, ХА-2, ХА-3, ОС-1 мэдээ)-ний алдааг дараах байдлаар ангилан бүртгэж баримтжуулна.

Д/д	Алдааны төрөл	Мэдээ дамжуулснаас хойшхи хугацаа					
		14 хоног	1 сар	45 хоног	2 сар	75 хоног	3 сар+
1	Балансын болон Логик (Үзүүлэлт хоорондын уялдаа)	0.5	1.0	1.5	2.0	2.5	3.5
2	Үзүүлэлт дутуу нөхөх	0.5	1.0	1.5	2.0	2.5	3.5
3	Үзүүлэлтийг орон, цэг, таслалын алдаатай шивэх	0.5	1.0	1.5	2.0	2.5	3.5
4	Үзүүлэлтийг маягтад заасан хэмжих нэгжээр тооцож ирүүлээгүй	0.5	1.0	1.5	2.0	2.5	3.5
5	Үзүүлэлтийг тайлбаргүйгээр хэт зөрүүтэй ирүүлэх (өссөн/буурсан)	0.5	1.0	1.5	2.0	2.5	3.5
6	Мэдээ, тайланг нэгтгэснээс хойш болон нийтэд зарлагдсан мэдээлэлд залруулга хийх	0.5	1.0	1.5	2.0	2.5	3.5
	Алдаатай үзүүлэлтийн нийлбэр						

$$\text{ШЗ.2.1} = (100\% - \text{Алдаатай үзүүлэлтийн нийлбэр хувь}) \times 5$$

ШЗ.2.2. Аж ахуйн нэгж байгууллагын мэдээ (НБХҮ-1, ЭШС-1, СБТ-1, СХ-1, СС-1, ХТ-1, ОСНАА-1)-нд гарсан алдааг дараах байдлаар бүртгэж, баталгаажуулна.

- Салбар хариуцсан ажилтнууд ААНБ-ын мэдээнд гаргасан үзүүлэлтийн алдааг үзүүлэлтийг дутуу нөхөх, үзүүлэлтийг тайлбаргүйгээр хэт зөрүүтэй ирүүлэх (өссөн/ буурсан), үзүүлэлтийг орон, цэг, таслалтын алдаатай шивэх, маягтад заасан хэмжих нэгжээр тооцож ирүүлээгүй, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүтээгдэхүүн үйлчилгээ, ажил мэргэжлийн болон

бусад ангиллын кодыг буруу нөхөх, балансын болон логик (үзүүлэлт хоорондын уялдаа)-ийн алдаа, мэдээ, тайланг нэгтгэснээс хойш болон нийтэд зарласан мэдээлэлд залруулга хийх гэсэн алдааны төрлөөр ангилан бүртгэж баримтжуулсан байна.

- ААНБ-ын мэдээний алдаатай үзүүлэлтийг програмд бичигдсэн үр дүнгийн файлыг ашиглан бүртгэнэ. ААНБ-аар ирүүлсэн мэдээний эхний болон сүүлийн үр дүнгийн файлыг үзүүлэлт бүрээр тулгаж, өөрчлөлт оруулсан бичилтээр “Алдаатай үзүүлэлтийн тоо”-г бүртгэнэ.

Салбар хариуцсан ажилтнуудын алдааны төрлөөр нь ангилж, нэгтгэсэн алдааны үзүүлэлтийн тоо нь програмд бичигдсэн үр дүнгийн файлаар бүртгэгдсэн алдааны үзүүлэлтийн тоотой ойролцоо байна.

Тухайн салбарын мэдээний онцлог байдлаас шалтгаалан гарсан зарим алдааг алдаанд тооцох эсэхийг салбар хариуцсан ажилтан шийднэ. Тухайлбал, мэдээний сар, улирлын гүйцэтгэл алдаатай байснаас жилийн дүнд буюу өссөн дүнгийн гүйцэтгэлд алдаа гарсныг алдаанд тооцохгүй байж болно. Өөрөөр хэлбэл, нэг нь нөгөөгөөс шалтгаалсан алдааг алдаанд тооцохгүй.

Дээрх 2 бүртгэл дээр үндэслэн баталгаажуулсан алдаатай үзүүлэлтийн тоог алдааны хувийг тооцоход ашиглана.

$$ШЗ.2.2 = \left(1 - \frac{\text{Алдаатай үзүүлэлтийн тоо}_i}{\text{Нөхөж ирүүлсэн нийт үзүүлэлтийн тоо}_i} \right) \times 5$$

- i - тухайн салбар

ШЗ.3. Үнийн мэдээ: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, салбарын үйлдвэрлэгчийн үнэ, барилгын өртгийн үнэ гэж авч үзнэ. Үүнд:

Хүснэгт 2. Үнийн мэдээ, түүнд ашиглах оноо

№	Салбар	Оноо
1	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ	6.0
2	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	3.0
3	Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ	3.0
4	Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнэ	3.0
5	Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ	3.0
6	Мэдээлэл холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнэ	3.0
7	Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнэ	3.0
8	Зоогийн газрын салбарын үйлдвэрлэгчийн үнэ	3.0
9	Барилгын өртгийн үнэ	3.0

$$\text{Чанар} = \left(1 - \frac{\text{Алдаатай ирүүлсэн бараа, үйлчилгээний тоо}}{\text{Сагсан дахь ирүүлбэл зохих нийт бараа, үйлчилгээний тоо}} \right) \times 30$$

Барилгын өртгийн үнийн мэдээний хувьд улирал бүр мэдээнд хамрагдах ААНБ болон бараа, бүтээгдэхүүний үнэ харилцан адилгүй байдаг тул сагсан дахь нийт бараа, үйлчилгээний үнийг тухайн улиралд ирүүлсэн бараа, бүтээгдэхүүний нийт үнээр авч үзнэ.

$$\text{Чанар} = \left(1 - \frac{\text{АИББҮТ}}{\text{ТУИНББҮТ}} \right) \times 30$$

- АИББҮТ – Алдаатай ирүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнийн тоо
- ТУИНББҮТ – Тухайн улиралд ирүүлсэн нийт бараа, бүтээгдэхүүний үнийн тоо

Хүн ам, өрхийн мэдээллийн сан (Ш4): Засаг захиргааны анхан шатны нэгжид хөтлөгдөж буй ХАӨМС-гийн ажлын үр дүнг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ. Үүнд:

$$\text{Ш4} = \text{Ш4.1 (12.0 оноо)} + \text{Ш4.2 (18.0 оноо)}$$

Ш4.1.Баяжилт, шилжих хөдөлгөөний бүртгэл: Сум, хорооны Засаг даргын захиргааны бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын төрөлт, нас баралтын бүртгэлтэй тулгаж дараах томъёогоор оноог тооцно.

$$\text{Ш4.1} = \text{Баяжилт (6.0 оноо)} + \text{Шилжих хөдөлгөөний бүртгэл ШХБ (6.0 оноо)}$$

$$\text{Баяжилт} = \frac{\left(\frac{\text{ХАӨМС} - \text{ийн төрөлт}}{\text{УБЕГ} - \text{ын төрөлт}} + \frac{\text{ХАӨМС} - \text{ийн нас баралт}}{\text{УБЕГ} - \text{ын нас баралт}} \right)}{2} \times 6$$

$$\text{ШХБ} = \left(2 * \left(2 - \frac{\text{ШБХА}_{6 \text{ сар}+}}{\text{ШБХА}} - \frac{\text{ШХХА}_{6 \text{ сар}+}}{\text{ШХХА}} \right) \right) + \left(4 * \left(1 - \left(\frac{\text{ШБХА} + \text{ШХХА}}{\text{Хүн амын нийт тоо}} \right) \right) \right)$$

- ШБХА_{6 сар+} - Шилжилт 6 сараас дээш хугацаагаар баталгаажаагүй хүн ам
- ШБХА - Шилжилт баталгаажаагүй нийт хүн ам
- ШХХА_{6 сар+} - Шилжилт 6 сараас дээш хугацаагаар хүлээгдэж буй хүн ам
- ШХХА - Шилжилт хүлээгдэж буй нийт хүн ам

Ш2.2. Чанар: Хүн ам, өрхийн үзүүлэлтэд гарч буй алдаа болон өрхийн цэг тэмдэглэлтийг байдлыг харгалзан дараах байдлаар тооцно. Үүнд:

$$\text{Ш4.2} = \text{Үзүүлэлтийн алдаа (12.0 оноо)} + \text{Өрхийн цэг тэмдэглэлт (6.0 оноо)}$$

$$\text{Үзүүлэлтийн алдаа} = 6 * \left(1 - \frac{\text{ХАҮАХТ}}{\text{Хүн амын нийт тоо}} \right) + 6 * \left(1 - \frac{\text{ӨҮАӨТ}}{\text{Өрхийн нийт тоо}} \right)$$

- ХАҮАХТ - Хүн амын үзүүлэлтийн алдаатай хүний тоо
- ӨҮАӨТ - Өрхийн үзүүлэлтийн алдаатай өрхийн тоо

$$\text{Өрхийн цэг тэмдэглэлт} = 6 * \left(1 - \frac{\text{ХӨАМС} - \text{нд цэг тэмдэглээгүй өрхийн тоо} + \text{Өрхийн цэгийг аймгийн хилийн гадна тэмдэглэсэн өрхийн тоо}}{\text{Өрхийн нийт тоо}} \right)$$

Бизнес регистрийн мэдээлийн сан (Ш5): “Статистикийн бизнес регистрийг хөтлөх, ашиглахад баримтлах журам”-ын дагуу аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газар нь бизнес регистрийн жилийн засвар, өөрчлөлтийг жил бүрийн 11-р сарын 30-ны дотор хийнэ.

Дээрх засвар өөрчлөлтийн дараа “ААНБ-ын 201... оны үйл ажиллагааны мэдээ”-ний хүрээг бизнес регистрийн сангаас бэлтгэх ба тус хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа гэж орсон боловч мэдээ ирэхдээ ААНБ-ыг шалтгаантай (Х тайлантай, үйл ажиллагаа явуулаагүй, үйл ажиллагаа эхлээгүй, үйл ажиллагаа түр зогссон, татан буугдсан, ААНБ олдохгүй, хаягтаа байхгүй, эзэн нь нас барсан гэх мэт бусад шалтгаантай эсвэл үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн) гэж ирүүлсэн бол бизнес регистрийн засвар, өөрчлөлтийг хангалтгүй хийсэн гэж үзэж, Ш5-н дүнд нөлөөлнө.

$$\text{Ш5} = \frac{\text{ААНБ} - \text{ын 201} \dots \text{оны үйл ажиллагааны мэдээ өгсөн ААНБ} - \text{ын тоо}}{\text{ААНБ} - \text{ын 201} \dots \text{оны үйл ажиллагааны мэдээний хүрээнд хамрагдсан ААНБ} - \text{ын тоо}} \times 30$$

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Мал тэжээвэр амьтдын тооллого (Ш6): Жилийн эцсийн тооллогын ажлыг дараах 2 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

$$\text{Ш6} = \text{Ш6.1 (45.0 оноо)} + \text{Ш6.2 (10.0 оноо)} + \text{Ш6.3 (20.0 оноо)}$$

Ш6.1. Тооллогын мэдээллийн чанар:

$$\text{Ш6.1} = \left(1 - \frac{\text{Алдаатай үзүүлэлтийн тоо} * 5}{\text{Нөхөж ирүүлсэн нийт үзүүлэлтийн тоо}} \right) \times 45$$

Малын тооллогын урьдчилсан дүнг гарсны дараа мал тооллогын дүнд (малчдын мэдээлэл, малын тоо, малын орлого, зарлагын хөдөлгөөн, төллөх малын өөрчлөлт, төлийн тооны өөрчлөлт,) орсон өөрчлөлтөөр алдааг бүртгэх бөгөөд гарсан “1 алдааг 5 оноотой тэнцүү” гэж үзнэ.

Үүнд, мөн мал тооллогоор цуглуулсан тэжээвэр амьтад, үйлдвэрлэл, борлуулалт, нутгийн шилдэг омог, цэвэр, үүлдэр, эрлийз мал, нутгийн сайжруулсан үүлдрийн малын тоо, бэлтгэсэн хадлан, тэжээл, аргал, хөрзөн, түлшний мод, ХАА-н үйлдвэрлэлд ашиглаж байгаа машин, техник, худаг, усан сан, малын хашаа, малчин өрхийн ахуйн зарим үзүүлэлт, ХАА-н үйлдвэрлэлд ажиллаж байгаа боловсон хүчин, малын даатгал, эрчимжсэн аж ахуйн талаарх мэдээлэлд 1 сарын 10-наас хойш засвар оруулсан тохиолдолд үүнийг алдаа гэж үзэж, дээрх тооцоололд хамруулна.

Алдааны тоо нь хамрагдвал зохих өрх, ААНБ-ын тооноос илүү гарсан тохиолдолд чанарын оноог 0-ээр тооцно.

Өрхийн мэдээнд гарсан алдаатай үзүүлэлтийг дараах байдлаар бүртгэнэ. Үүнд:

- Салбар хариуцсан ажилтнууд энэхүү журмын хүснэгт 3-д тусгасны алдааны төрлөөр өрхийн мэдээнд гарсан үзүүлэлтийн алдааг ангилан бүртгэнэ.
- Алдаатай үзүүлэлтийг програмд бичигдсэн "log" файлыг ашиглан бүртгэнэ.

Өрхөөр ирүүлсэн мэдээний эхний болон сүүлийн "log" файлыг үзүүлэлт бүрээр тулгаж, өөрчлөлт оруулсан бичилтээр "Алдаатай үзүүлэлтийн тоо"-г тодорхойлно.

"log" файлд бүртгэгдсэн алдаатай үзүүлэлтийн тоо нь салбар хариуцсан ажилтнууд дээр алдааны төрлөөр нэг бүрчлэн бүртгэсэн алдаатай үзүүлэлтийн тоотой тэнцүү буюу ойролцоо байна.

Тухайн мэдээний онцлог байдлаас шалтгаалан гарсан зарим алдааг алдаанд тооцох эсэхийг салбар хариуцсан ажилтан шийднэ. Тухайлбал, Нэг үзүүлэлт алдаатай байснаас өөр нэг үзүүлэлт нь алдаатай болсныг алдаанд тооцохгүй байж болно. Жишээлбэл, Гарсан төлийн тоог буруу өгснөөс бойжуулсан төлийн тоог програм автоматаар бодож, алдаанд бүртгэгдэн засагдсныг алдаанд бүртгэхгүй.

Дээрх 2 бүртгэл дээр үндэслэн баталгаажуулсан алдаатай үзүүлэлтийн тоог алдааны хувийг тооцоход ашиглана.

Хүснэгт 3. Мал, тэжээвэр амьтдын тооллогод гардаг алдааны төрөл

№	Салбар
1	Логик (үзүүлэлт хоорондын уялдаа), балансын алдаа
2	Үзүүлэлт дутуу нөхөх
3	Үзүүлэлтийг орон, цэг, таслалын алдаатай шивэх\
4	Үзүүлэлтийг маягтад заасан хэмжих нэгжээр тооцож ирүүлээгүй
5	Үзүүлэлтийг тайлбаргүйгээр хэт зөрүүтэй ирүүлэх (өссөн/буурсан)
6	Ангилал, кодыг буруу нөхөх
7	Том малын зүй бус хорогдол, мал төллөлт, төл бойжилтын явцын мэдээнээс 15 хувиас илүү зөрүүтэй /байгалийн гамшигт үзэгдэл болон мал амьтны гаралтай халдварт өвчний шалтгаанаас бусад тохиолдолд
8	Малтай өрх болон малчин өрхийн тоо өмнөх оныхоос үндэслэлгүй өөрчлөгдсөн.
9	Мэдээ, тайланг нэгтгэснээс хойш болон нийтэд зарлагдсан мэдээлэлд залруулга хийх

Ш6.2. Тооллогын хяналт:

Мал тооллогоор тоологдсон нийт өрх, ААНБ болон хяналтын тооллогод хамрагдсан өрх, ААНБ-ын хамралтыг харгалзан дараах байдлаар үнэлнэ.

Хяналтын тооллогыг нийт тооллогод хамрагдсан өрх, ААНБ-ын 10 хувьтай тэнцэх хэсэгт хийнэ. Үүнд:

$$Ш6.2 = \frac{\text{Хяналтын тооллогод хамрагдсан өрх, ААНБ – ын тоо}}{\text{Хяналтын тооллогод хамрагдах ёстой өрх, ААНБ – ын тоо}} \times 10$$

Ш6.3. Тооллогын мэдээллийн дамжуулалт:

$$Ш6.3 = 20 - \text{Хугацаа хоцроосон хоногийн тоо} * 5$$

- Дөрөв, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд шууд 0.0 оноо өгнө.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (Ш7): Дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

$$Ш7 = Ш7.1 (20.0 \text{ оноо}) + Ш7.2 (30.0 \text{ оноо}) + Ш7.3 (25.0 \text{ оноо})$$

Ш7.1. Түүвэр судалгааны хамралт:

$$Ш7.2 = 20 - \left(\frac{\text{Нөөц өрхийн тоо}}{\text{Хамрагдвал зохих өрхийн тоо}} \right) - \text{СХӨТ}$$

- СХӨТ- Судалгаанд хамруулаагүй өрхийн тоо

Ш7.2. Мэдээллийн чанар:

$$Ш7.2 = \left(1 - \frac{\text{Алдаатай үзүүлэлтийн тоо}}{\text{Нийт үзүүлэлтийн тоо}} \right) \times 30$$

Нийт үзүүлэлтийн тоо

$$= \text{Хамрагдвал зохих өрхийн тоо} * \text{Нэг өрхөөс авах үзүүлэлтийн тоо}$$

Ш7.3. Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт:

$$Ш7.3 = 25 - \text{Хугацаа хоцроосон хоногийн тоо} * 2$$

- 10 ба түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд 0 оноо өгнө.
- Мэдээлэл дамжуулалтын жилийн эцсийн үнэлгээг гаргахдаа улирлын үнэлгээг харгалзахгүйгээр жилийн дүнгээр хоцорсон хугацааг нэгтгэж тооцно.

Ажиллах хүчний судалгаа (Ш8): Дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ.

$$Ш8 = Ш8.1 (20.0 \text{ оноо}) + Ш8.2 (40.0 \text{ оноо}) + Ш8.3 (15.0 \text{ оноо})$$

Ш8.1. Түүвэр судалгааны хамралт:

$$Ш8.1 = 20 - \left(\frac{\text{Нөөц өрхийн тоо}}{\text{Хамрагдвал зохих өрхийн тоо}} \right) - \text{СХӨТ}$$

- СХӨТ- Судалгаанд хамруулаагүй өрхийн тоо

Ш8.2. Мэдээллийн чанар:

$$Ш8.2 = 40 * \left| 1 - \frac{\text{Алдаатай үзүүлэлтийн тоо}}{\text{Нийт үзүүлэлтийн тоо}} \right|$$

Нийт үзүүлэлтийн тоо

= Хамрагдвал зохих өрхийн тоо * Нэг өрхөөс авах үзүүлэлтийн тоо

Ш8.3. Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт:

Ш8.3 = 15 – Хугацаа хоцроосон хоногийн тоо * 2

- 5 ба түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд 0 оноо өгнө.

Эдийн засгийн түүвэр судалгаа (Ш9): Тухайн жилд явагдсан судалгаануудын үнэлгээний дунджаар тооцно. Судалгааг өрхөд суурилсан, ААНБ-ын түүвэр судалгаа гэж ангилж дүгнэнэ. Өрхөд суурилсан эдийн засгийн түүвэр судалгааны хувьд ӨНЭЗС-тай адил зарчмаар дүгнэнэ. ААНБ-ын түүвэр судалгааг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

Эдийн засгийн түүвэр судалгааны ажлыг дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

Ш9 = Ш9.1 (20.0 оноо) + Ш9.2 (40.0 оноо) + Ш9.3 (15.0 оноо)

Ш9.1. Түүвэр судалгааны хамралт:

Ш9.1 = $\frac{\text{Мэдээнд хамрагдсан статистик нэгжийн тоо}}{\text{Хамрагдвал зохих нийт статистик нэгжийн тоо}} \times 20$

Ш9.2. Мэдээллийн чанар: үнэлгээг тооцохдоо шалгуур үзүүлэлт 3-тай адил зарчмаар дүгнэнэ.

Ш9.3. Түүвэр судалгааны мэдээлэл дамжуулалт:

Ш9.3 = 15 – Хугацаа хоцроосон хоногийн тоо * 5

- Гурав, түүнээс дээш хоногоор хоцроосон тохиолдолд шууд 0.0 оноо өгнө.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ,
СУРТАЛЧИЛГАА**

Мэдээлэл тархаалт, вэб баяжилт, сурталчилгаа (Ш10): Дараах 3 хэсэгт хувааж авч үзнэ. Үүнд:

Ш10 = Ш10.1 (10.0 оноо) + Ш10.2 (10.0 оноо) + Ш10.3 (80.0 оноо)

Ш10.1. Олон нийтэд мэдээлэл түгээсэн байдал: Сар бүр статистикийн мэдээллээр олон нийт болон төрийн байгууллагад мэдээлэл түгээсэн байх. Статистикийн мэдээлэл түгээх арга хэмжээ зохион байгуулсан тайланг сонин хэвлэлд нийтлүүлсэн материалын хамт хавсарган улирал бүр ирүүлнэ. Орон нутгийн телевиз, сонин хэвлэлд сурталчилсан байна. Тайланг улирал бүрийн дараагийн ажлын эхний долоо хоногт багтаан Тамгын газрын ОНХХ-т ирүүлнэ.

Ш10.1 = ОНМТБ тайлан * $\frac{5.0 \text{ оноо}}{4 \text{ улирал}}$

Тайланг хугацаандаа ирүүлсэн байдлаар дараах хүснэгтийн дагуу тооцно. 5 оноо

Хугацаандаа	5.0 оноо
Хугацаанаас хойш	2.5 оноо

Ш10.2. Тооллого, судалгааны сурталчилгаа: Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйл, “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуулийн дагуу ҮСХ-ноос тухайн жилд зохион байгуулж байгаа тооллого, судалгааны талаар улирал тутам мэдээлэл бэлтгэж, сурталчлах бөгөөд тайланг ажлын 3 хоногт багтаан ТГ-ын ОНХХ-т ирүүлнэ.

$$Ш10.2 = \text{Тооллого судалгааны ажлыг сурталчилсан тоо} * \frac{10.0 \text{ оноо}}{4 \text{ (улирал)}}$$

Ш10.3. Мэдээлэл тархаалт, вэб баяжилт: Үнэлгээг тооцохдоо сарын бюллетень, танилцуулга, жилийн эмхэтгэлийг тархаасан байдал, аймаг, нийслэлийн хөгжлийн үндсэн болон статистикийн эмхэтгэлийн үзүүлэлтээр засаг захиргааны нэгжээр динамик бүрдүүлсэн байдал, аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийн голлох үзүүлэлтээр танилцуулга бэлтгэн тархаасан байдал, инфографик бэлтгэн тархаасан байдлыг харгалзан дараах байдлаар тооцно.

$$Ш10.3 = \text{БТ (20.0 оноо)} + \text{ДҮ (20.0 оноо)} + \text{ЖЭ (10.0 оноо)} + \text{СТ (20.0 оноо)} \\ + \text{ИМ (10.0 оноо)}$$

- БТ - Бюллетень, танилцуулга
- ДҮ - Динамик үзүүлэлт, бүрдүүлэлт
- ЖЭ - Жилийн эмхэтгэл
- СТ - Салбарын танилцуулга
- ИМ - Инфографик мэдээлэл

Бюллетень, танилцуулга: Сарын бюллетень, танилцуулгыг дараа сарын 15-ны дотор газар, хэлтсийн вэб хуудаст оруулсан байна. Өмнөх оны эцсийн болон тайлант оны эхний 11 сарын байдлаар нийт 12 удаа бюллетень, танилцуулгыг бэлтгэн байршуулсан байна. Сарын бюллетень, танилцуулгын доторх агуулга, загвар дизайн, үсгийн фонт, үсгийн хэмжээ зэргийг харгалзан дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

$$БТ = \left(\frac{ВСББТТ}{ТЖХГБТТ} \times 12 \right) + \left(\frac{ЗСДББТТ}{ТЖХГБТТ} \times 8 \right)$$

- ВСББТТ – Вэб сайтад байршуулсан бюллетень, танилцуулгын тоо
- ЗСДББТТ - Загвар стандартын дагуу боловсруулсан бюллетень, танилцуулгын тоо
- ТЖХГБТТ – Тухайн жилд хийж гүйцэтгэх бюллетень, танилцуулгын тоо

Бюллетень, танилцуулгын загвар стандарт, үг үсэг, найруулгын алдааг дараах үзүүлэлтээр дүгнэнэ.

№	Алдааны төрөл	Оноо
1	Үг үсэг, найруулгын алдаа (үсгийн фонт, ... г.м)	0.5
2	Загвар стандарт (хуудасны хэмжээ, хүснэгт, график ... г.м)	0.5

Нийт дүн	1.0
----------	-----

Динамик үзүүлэлт, бүрдүүлэлт: Статистикийн хэлтэс, газар нь аймаг, нийслэлийн хөгжлийн үндсэн болон статистикийн эмхэтгэлийн үзүүлэлтээр засаг захиргааны нэгжээр динамик бүрдүүлсэн байна. Динамик нь тухайн засаг захиргааны нэгж байгуулагдсан оноос эхэлсэн байх бөгөөд ҮСХ-ноос тухайн үзүүлэлтийг зарлахыг зөвшөөрснөөс хойш 10 хоногийн дотор шинэчлэн баяжуулна.

№	Хугацааны төрөл	Оноо
1	Хугацаандаа	10.0
2	Хугацаанаас хойш	5.0
3	Бүрэн биш	0
Нийт дүн		10.0

Аймаг, нийслэлийн статистикийн мэдээллээр 5-аас доошгүй хугацааг (сар, улирал, жил гэх мэт) хамруулан, мөн хамгийн бага нэгжийн түвшинд /баг, хороогоор задарсан гэх мэт/ бүхий мэдээлэл бэлтгэн улирал тутам оруулах.

5, түүнээс дээш салбар хамруулсан бол	10.0 оноо
4 салбар	8.0 оноо
3 салбар	6.0 оноо
2 салбар	4.0 оноо
1 салбар	2.0 оноо

Жилийн эмхэтгэл: Эмхэтгэлийг 6 дугаар сарын 30-ны дотор газар, хэлтсийнхээ вэб хуудсанд оруулсан байна. 5.0 оноо

Хугацаандаа	5.0 оноо
Хугацаанаас хойш	2.5 оноо
Бүрэн биш	0 оноо

Жилийн эмхэтгэлийн доторх агуулга, загвар дизайн, үсгийн фонт, үсгийн хэмжээ зэргийг харгалзан дараах байдлаар дүгнэнэ. Үүнд: 5.0 оноо

№	Алдааны төрөл	Оноо
1	Үг үсэг, найруулгын алдаа (үсгийн фонт, ... г.м)	2.5
2	Загвар стандарт (хуудасны хэмжээ, хүснэгт, график ... г.м)	2.5
Нийт дүн		5.0

Салбарын танилцуулга: Статистикийн хэлтэс, газар нь дараах ерөнхий сэдвийн хүрээнд боловсруулж бэлтгэн жил бүрийн 07 сарын 01-ний өдрийн дотор вэб хуудсандаа байршуулсан байна. Үүнд:

№	Хугацааны төрөл	Оноо
1	“Аймаг, нийслэлийн хүн ам, өрх”	5.0

2	“Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлт”	5.0
3	Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга	5.0
4	Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга	5.0
Нийт дүн		20.0

Инфографик мэдээлэл: Аймаг, нийслэлийн статистикийн мэдээллээр 5-аас доошгүй хугацааг (сар, улирал, жил гэх мэт) хамруулан инфографик бүхий мэдээлэл бэлтгэн улирал тутам оруулах.

№	Хугацааны төрөл	Оноо
1	“Аймаг, нийслэлийн хүн ам, өрх”	3.0
2	“Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлт”	2.0
3	Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга	3.0
4	Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга	2.0
Нийт дүн		10.0

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨРИЙН ЗАХИРГАА, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дотоод үйл ажиллагаа (Ш11): Нэгжийн дотоод үйл ажиллагааг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

$$Ш11 = Ш11.1 (30.0 \text{ оноо}) + Ш11.2 (30.0 \text{ оноо}) + Ш11.3 (20.0 \text{ оноо})$$

Ш11.1 Төлөвлөлт, тайлагналт: Аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газрын үйл ажиллагааг Статистикийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу оновчтой төлөвлөж, төлөвлөгөөний биелэлт, тайланг товч тодорхой, үнэн зөв тайлагнасан, архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдсөн байдлыг харгалзан дараах оноог өгнө.

$$Ш11.1 = \text{Төлөвлөлт} (20.0 \text{ оноо}) + \text{Тайлагналт} (10.0 \text{ оноо})$$

Төлөвлөлт: Нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлтийг харгалзан дараах оноог өгнө. Үүнд:

Үнэлэх шалгуур	Авбал зохих оноо
Нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, тогтоосон хугацаанд ирүүлсэн байдлыг харгалзан	4.0 оноо
Хэрэгжүүлэх арга хэмжээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо хэмжээ, чанар, хугацаа, хүрэх түвшин)-ийг оновчтой төлөвлөсөн байдлыг харгалзан	8.0 оноо
Үг үсэг, найруулгын алдааг харгалзан	4.0 оноо
Архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдсөн байдлыг харгалзан	4.0 оноо

Тайлагналт: Тайлангийн баримтжуулалт, иж бүрдэл, архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдсөн байдлыг харгалзан дараах оноог өгнө. Үүнд:

Үнэлэх шалгуур	Авбал зохих оноо
Нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон тайланг гаргаж, тогтоосон хугацаанд ирүүлсэн байдлыг харгалзан	3.0 оноо
Тайлангийн баримтжуулалтыг харгалзан	3.0 оноо
Үг үсэг, найруулгын алдааг харгалзан	2.0 оноо
Архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдсөн байдлыг харгалзан	2.0 оноо

Ш11.2. Засаг даргын үнэлгээ: ҮСХ-ны дарга, аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газрын дарга болон Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэсэн Засаг даргын үнэлгээг харгалзан дараах байдлаар тооцно. Үүнд:

$$Ш11.2 = \frac{\text{Засаг даргаас өгсөн үнэлгээ} * 30 \text{ оноо}}{100\%}$$

Ш11.3. Шинэ санаа, санаачилга: Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, ажиллах орчин нөхцөл сайжруулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг харгалзан дараах байдлаар тооцно. Үүнд:

Шалгуур	Авбал зохих оноо
Албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан байдлыг харгалзан	5.0 оноо
Албан хаагчийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг харгалзан	5.0 оноо
Албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааг харгалзан	5.0 оноо
Шинээр санаачлан хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг харгалзан	5.0 оноо

Сургалтын үйл ажиллагаа (Ш12): Статистикийн салбарын албан хаагчид болон хэрэглэгчдэд зохион байгуулсан сургалтын үйл ажиллагааг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

$$Ш12 = Ш12.1 (10.0 \text{ оноо}) + Ш12.2 (10.0 \text{ оноо}) + Ш12.3 (10.0 \text{ оноо})$$

Ш12.1. Нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт: Баг, хороо, сум, дүүргийн статистикийн мэдээ хариуцсан (баг, хорооны Засаг дарга, сумын төрийн сангийн төлөөлөгч зэрэг) ажилтнуудад зориулсан сургалтыг жил бүр ээлжлэн зохион байгуулж, нийт хэчнээн баг, хороо, сум, дүүргийн статистикийн мэдээ хариуцсан ажилтнууд хамрагдсан талаарх бүртгэлийг хийж, заасан хичээлийн материалыг хавсаргасан илтгэх хуудсыг ирүүлнэ. (Сургалт зохион байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногт ирүүлэх)

Ирц: хамралт 2.0 оноо, (хамралтыг тухайн аймгийн баг, хороо, сумдын тоогоор тооцно)

Хичээлийн материал: сэдэв 8.0 оноо

№	Сэдвийн шалгуур үзүүлэлт	Оноо
1	Албан ёсны статистикийн үйл ажиллагаа	1.0
2	Хүн ам, нийгмийн статистикийн мэдээ гаргах аргачлал, заавар	1.5
3	Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн хэрэглээ, программ	1.5
4	Монгол Улсын Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баг, хороо, сумдын статистикийн мэдээ хариуцсан ажилтнуудын үүрэг, оролцоо	1.0
5	Салбарын статистикийн мэдээ, тайлан гаргах аргачлал заавар	1.5
6	Мал тооллогын мэдээллийн сангийн хэрэглээ, программ	1.5

- Тухайн хугацаанд тайлан ирүүлээгүй бол – 0.0 оноо

Ш12.2. Оюутан, сурагчдад зориулсан сургалт: Статистикийн хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд Их, дээд сургуулийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалтыг зохион байгуулж, хамрагдсан оролцогчдын тоог авч, статистикийн бүтээгдэхүүн, сурталчилгааны материал тарааж, хамрагдсан оролцогчдоос сургалтын үнэлгээний асуулга авч, заасан хичээлийн материал, асуулгын дүн, үйл явцын зургийг хавсаргасан илтгэх хуудсыг ирүүлнэ. (Сургалт зохион байгуулсан өдрөөс хойших ажлын 5 хоногт ирүүлэх)

Тайланд үйл явцыг харуулсан зураг, хамралт, тараасан материал, асуулгын дүнг тусгах бөгөөд 0.0-10.0 оноо өгнө.

Дээрх 2 төрлийн сургалт бүр 10.0 оноо өгнө. Дараах шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	Тухайн сургалтын хичээлийн сэдэв	3.0
2	Оролцогчдын хамралт	2.0
3	Сургалтад тараасан материал	3.0
4	Оролцогчдоос авсан санал асуулгын дүн	1.0
5	Сургалтын үйл явцын зураг	1.0

- Тухайн хугацаанд тайлан ирүүлээгүй бол – 0.0 оноо

Ш12.3. Статистикийн мэдээлэгч нарт зориулсан сургалт: Статистикийн хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд статистикийн анхдагч мэдээллийг бүрдүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад сургалтыг зохион байгуулж, хамрагдсан оролцогчдын тоог авч, статистикийн бүтээгдэхүүн, сурталчилгааны материал тарааж, хамрагдсан оролцогчдоос сургалтын үнэлгээний асуулга авч, заасан хичээлийн материал, асуулгын дүн, үйл явцын зургийг хавсаргасан илтгэх хуудсыг ирүүлнэ. (Сургалт зохион байгуулсан өдрөөс хойших ажлын 5 хоногт ирүүлэх)

Тайланд үйл явцыг харуулсан зураг, хамралт, тараасан материал, асуулгын дүнг тусгах бөгөөд 0.0-10.0 оноо өгнө.

Дээрх 2 төрлийн сургалт бүр 10.0 оноо өгнө. Дараах шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	Тухайн сургалтын хичээлийн сэдэв	3.0
2	Оролцогчдын хамралт	2.0
3	Сургалтад тараасан материал	3.0
4	Оролцогчдоос авсан санал асуулгын дүн	1.0
5	Сургалтын үйл явцын зураг	1.0

- Тухайн хугацаанд тайлан ирүүлээгүй бол – 0.0 оноо

Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа (Ш13): Архив, албан хэрэг, хөтлөлтийн үйл ажиллагааг дараах байдлаар тооцно. Үүнд:

$$Ш13 = Ш13.1 (20.0 \text{ оноо}) + Ш13.2 (20.0 \text{ оноо})$$

Ш13.1. Албан хэрэг хөтлөлтийн журам, стандарт: Нэгжээс явуулсан албан бичиг, тушаал болон бусад баримт бичгийн боловсруулалтыг харгалзан дараах байдлаар тооцно. Үүнд:

- Стандартын мөрдсөн байдлыг харгалзан 1-5.0 оноо
- Үг үсэг, найруулгын алдааг харгалзан 1-7.0 оноо
- Баримт бичгийн бүрдлийг харгалзан 1-8.0 оноо

Ш13.2. Архивын ажлын зохион байгуулалт:

- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг загварын дагуу боловсруулан баталж, ирүүлсэн байдлыг харгалзан 1-5.0 оноо
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын баримт бичгийн хадгалах хугацааг зөв тогтоосон байдлыг харгалзан 1-5.0 оноо
- Хадгаламжийн нэгжийн жагсаалтыг загварын дагуу боловсруулан баталж, ирүүлсэн байдлыг харгалзан 1-10.0 оноо
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт болон Хадгаламжийн нэгжийн жагсаалтыг тухайн оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх бөгөөд хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд 0 оноо

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шилэн данс (Ш14): Цахим хуудсанд мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн байршуулсан байдлыг харгалзан дараах оноог өгнө. Үүнд:

- Мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол -1 оноо
- Мэдээллийг хугацаа хоцроосон бол -0.5 оноо
- Мэдээлэл шаардлага хангаагүй болон байршуулаагүй бол -0 оноо

$$Ш14 = \frac{ХБМТТ * 1 + ХХМТТ * 0.5}{\text{Байршуулах мэдээ, тайлангийн тоо}} * 25$$

- ХБМТТ - хугацаанд нь байршуулсан мэдээ, тайлангийн тоо
- ХХМТТ –хугацаа хоцроосон мэдээ,тайлангийн тоо

Санхүүгийн үйл ажиллагаа (Ш15): Төсөвт хөрөнгийн зарцуулалт, тайлагналт, аудитын дүгнэлтийг харгалзан дүгнэнэ.

$$Ш15 = Ш15.1 (40.0 \text{ оноо}) + Ш15.2 (5.0 \text{ оноо}) + Ш15.3 (12.0 \text{ оноо}) + Ш15.4 (10.0 \text{ оноо}) + Ш15.5 (38.0 \text{ оноо}) + Ш15.6 (20.0 \text{ оноо})$$

Ш15.1 Санхүүгийн тайлан: Санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд ирүүлсэн байдлыг харгалзан дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

№	Шалгуур үзүүлэлт	Иж бүрэн, хугацаандаа, үнэн зөв	Алдаатай тайлан	Хугацаа хоцроосон, тайлан гаргаагүй
1	Санхүүгийн байдлын тайлан	5	2	0
2	Санхүүгийн үр дүнгийн тайлан	5	2	0
3	Өмчийн өөрчлөлтийн тайлан	5	2	0
4	Мөнгөн гүйлгээний тайлан	5	2	0
5	Шалгах баланс /аккурэль болон мөнгөн суурьт/	5	2	0
6	Төсвийн гүйцэтгэлийн тайлан /цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын ангиллаар/	5	2	0
7	Тодруулгат тайлан, (Үндсэн хөрөнгө, бараа материал, өглөг, авлага, орон тоо, цалингийн сангийн тайлан)	5	2	0
8	Санхүүгийн тайлангийн тодруулга, илтгэх хуудас, танилцуулга, тодруулгат тайлангийн холбогдох шийдвэрүүд	5	2	0

Ш15.2. Санхүүгийн стандарт программын хэрэглээ: Сангийн яамны зөвшөөрөлтэй Aculous 3.0 санхүүгийн программаар өмнөх оны жилийн эцсийн болон тайлант оны 2 дугаар улирлын тайланг гаргаж ирүүлсэн бол 5 оноо, программ ашиглаагүй бол 0 оноо өгнө.

Ш15.3. Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ: мэдээг үнэн зөв, хугацаанд нь ирүүлсэн сар бүр 1 оноо өгнө.

Ш15.4. Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн тайлан: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөлт, жилийн эцсийн тооллогын бүртгэл, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт/-г дараа оны 2 дугаар сарын 25-ны дотор ҮСХ-ны Санхүүгийн хэлтэст ирүүлсэн тохиолдолд 10 оноо өгнө.

Ш15.5. Аудитын дүгнэлт: Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар нь аудитын зөрчилгүй дүгнэлт авсан бол 38 оноо, хязгаарлалттай болон сөрөг дүгнэлт авсан бол 0 оноо өгнө. Аудитын дүгнэлтийг үндэслэн дараах байдлаар оноог хасаж дүгнэнэ. Үүнд:

- Аудитаар өгсөн зөвлөмж 5 оноо
- Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга 5 оноо
- Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт 5 оноо
- Аудитын явцад өгсөн албан шаардлага 5 оноо
- Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал 5 оноо
- Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал 5 оноо
- Бусад 8 оноо

Ш15.6. Судалгааны зардлын зарцуулалтын тайлагналт: анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харгалзан дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

- Тайлагналт хугацаандаа, анхан шатны баримтын бүрдэл бүрэн бол 20.0 оноо
- Анхан шатны баримтын бүрдэл бүрэн боловч хугацаа хоцроосон бол 10.0 оноо
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хугацаа хоцорсон бол 0 оноо өгнө.

---oOo---